



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын
хоёрдугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/36/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь

2019 он

Тэргүүлэх аудитор: ...Ч.Ариунаа

Утас:7052-2734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 7052-3020 Цахим хаяг:

Аудитор: ..М.Бямбадорж

Утас: 99031981 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	
2	Аудитын тайлан	6
2.1	Оршил	6
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	8
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН ҮҮД
СУМЫН ХОЁРДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Т.БАТТУЯА ТАНАА

2019.02.27 № 4-6/242

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хоёрдугаар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт


Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хоёрдугаар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хоёрдугаар сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал:

- 2018 оны үйл ажиллагааны үр дүнд бий болсон төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэлгүйгээр Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэгч "Идэр өлзий дархан уул" ХХК-д 3249,2 мянган төгрөгийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал зардлаас, НДХ-д 3555,3 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгал болон цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлаас, "Чандмань бадрал" ХХК-д түлш халаалтын зардлаас 4998,5 мянган төгрөгийг тус тус илүү шилжүүлэн нийт 11802,9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.
- 2018 онд тус сургуулийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх /210902/ гэсэн эдийн засгийн ангилалаар 22820,9 мянган төгрөгийн төсөв батлагдан 100 хувийн гүйцэтгэлтэйгээр зарцуулагдсан байна. Уг ангилалын хүрээнд төсвийн шууд захирагч МУЗГ-ын 129 тоот тогтоолын шалгуур болгон ТБОНӨХБАҮХАТХ-ын 8,1 болон 8,4 заалтыг үндэслэл болгон худалдан авах ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллаагүй байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хууль 41.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8.-д "Тухайн байгууллага журмын 7.5-д заасан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг үндэслэх баримтын эх хувь, хяналтын хуудасны хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад: урсгал зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд төсвийн захирагчийн тушаал, төсвийн задаргааг баталсан хавсралт, товчоо, ажил, үйлчилгээ гүйцэтгэх, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой үнэлгээний хорооны шийдвэр, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын баримт, өр төлбөр байгааг нотолсон тооцоо нийлсэн акт, жижиг мөнгөн сангийн тайлан, банк дахь бэлэн мөнгөний дансны хуулга, хөрөнгийн зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн дансны хуулга болон бусад бичиг баримт хамаарна. Үндэслэх баримтын мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага хариуцна" заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Т.Баттуяа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018/02/21-наас 2018/02/22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018/02/22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2018/02/21-ны өдрийн 18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь Бага, дунд, суурь боловсрол олгох үйл ажиллагаа чанартай хүртээмжтэй хүргэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Боловсролын тухай хуулиар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх,

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын

хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр -ын хувиар сонгов.

-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь -холбоотой юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2018 оны мянган төгрөг бөгөөд түүний хувь болох мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг хувиар тооцсон нь холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	16,692.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	11,802.90	
3	Албан шаардлага өгсөн	1	22,820.90	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	51,315.80	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- 2018 оны үйл ажиллагааны үр дүнд бий болсон төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэлгүйгээр Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэгч "Идэр өлзий дархан уул" ХХК-д 3249,2 мянган төгрөгийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал зардлаас, НДХ-д 3555,3 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгал болон цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлаас, "Чандмань бадрал" ХХК-д түлш халаалтын зардлаас 4998,5 мянган төгрөгийг тус тус илүү шилжүүлэн нийт 11802,9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.
- 2018 онд тус сургуулийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх /210902/ гэсэн эдийн засгийн ангилалаар 22820,9 мянган төгрөгийн төсөв батлагдан 100 хувийн гүйцэтгэлтэйгээр зарцуулагдсан байна. Уг ангилалын хүрээнд төсвийн шууд захирагч МУЗГ-ын 129 тоот тогтоолын шалгуур болгон ТБОНӨХБАҮХАТХ-ын 8,1 болон 8,4 заалтыг үндэслэл болгон худалдан авах ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллаагүй байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Худалдан авах ажиллагааг ТБОНӨАБАҮХАТХ-ын дагуу хийсэн эсэх

Төсвийн хэмнэлтийг үр ашиггүй зарцуулж авлага, өглөг үүсгэх, Цалингаас хууль эрх зүйн актгүй суутгал суутгах

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1191613.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1190583.7 мянган төгрөг буюу 99,8 хувьтай байгаа нь батлагдсан төсвөөс 1030,1 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн бөгөөд хэмнэлтийн үндсэн шалтгаан нь ажил олгогчоос төлөх НДШ-аас шалтгаалжээ.

Өөрийн орлогын төлөвлөгөө тавигдаагүй

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан

заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Илрүүлэлт

Тайлант онд ажиллагсдын цалингаас хамтын санд 11806.0 мянган төгрөг, Жи мобайл утасны төлбөрт 4402.0 мянган төгрөг, өвөлжилтийн бэлтгэлд 10.0, Улаан загалмайд 470.0 мянган төгрөгийг тус тус суутгасан байна.

Зөвлөмж

Хөдөлмөрийн тухай хуулийн 63-аар зүйлийг мөрдөн ажиллаж шүүхийн шийдвэр болон холбогдох хууль эрх зүйн актгүйгээр ажиллагсдын цалингаас суутгал хийхгүй байх.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн захирал Т.Баттуяа, нягтлан бодогч Н.Сүрэнхүү

Эрсдэл

1. Ажиллагсдын гарт олгох цалин буурах.

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019/12/25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ч.АРИУНАА	Огноо:
АУДИТЫН МЕНЕЖЕР	Ц.ЛҮНДЭГМАА	Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР	М.БЯМБАДОРЖ	Огноо:
---------	-------------	--------

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 АУДИТАЛСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	59,281,692.85	62,744,266.24
33	АВЛАГА	20,467,722.00	12,010,613.44
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	3,583,452.44
335	Бусад авлага	20,467,722.00	8,427,161.00
3351	Байгууллагаас авах авлага	20,467,722.00	8,427,161.00
35	БАРАА МАТЕРИАЛ	38,813,970.85	50,733,652.80
351	Түүхий эд материал	52,905.00	52,905.00
35130	Эм боох материал	52,905.00	52,905.00
354	Хангамжийн материал	38,761,065.85	50,680,747.80
35410	Бичиг хэргийн материал	366,500.00	977,380.00
35420	Аж ахуйн материал	38,266,563.85	49,235,365.80
35440	Түлш, шатах тослох материал	60,000.00	400,000.00
35470	Бусад хангамжийн материал	68,002.00	68,002.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,802,508,178.60	4,609,195,019.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,802,508,178.60	4,609,195,019.47
392	Биет хөрөнгө	2,802,331,720.39	4,392,018,561.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,492,050,000.00	4,019,233,970.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(100,732,986.24)	(787,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	297,848,959.86	317,060,459.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,060,152.19)	(121,284,900.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	224,995,998.40	232,102,398.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(53,648,299.32)	(77,969,066.55)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,600,000.00	18,600,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(780,000.12)	(1,040,000.16)
39217	Ном	3,058,200.00	6,103,200.00
393	Биет бус хөрөнгө	176,458.21	217,176,458.21
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(593,541.79)	(593,541.79)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	217,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,861,789,871.45	4,671,939,285.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	58,311.00	44,092.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	58,311.00	44,092.06
413	Өглөг	58,311.00	44,092.06
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	22,011.00	17,792.06
4136	Бусад өглөг	36,300.00	26,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	24,500.00	24,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	11,800.00	1,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,861,731,560.45	4,671,895,193.65
51	Засгийн газрын хувь оролцоо	2,861,731,560.45	4,671,895,193.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	217,000,000.00
51101	Өмч: - төрийн	-	217,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,861,731,560.45	3,386,191,140.69
51210	Өмнөх үеийн үр дүн	2,861,731,560.45	2,861,731,560.45
51220	Тайлант үеийн үр дүн	-	524,459,580.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	1,068,704,052.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,861,789,871.45	4,671,939,285.71

Замын-Үүд ЕБ-ын 2 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,470,670,442.36	1,820,085,303.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	150,141,942.36	625,471,503.32
120	Нийтлэг татварын бус орлого	150,141,942.36	625,471,503.32
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	150,141,942.36	625,471,503.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,600,417.00	7,403,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	137,341,525.36	618,068,503.32
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,320,528,500.00	1,194,613,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,191,613,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,191,613,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,000,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-
1330	Төсвийн захирагчдаас	1,320,528,500.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,320,528,500.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,312,941,451.22	1,295,625,723.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,312,941,451.22	1,295,625,723.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,134,532,684.22	1,208,970,623.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	685,898,878.00	728,682,999.50
210101	Үндсэн цалин	487,590,839.00	532,665,661.50
210102	Нэмэгдэл	163,520,673.00	111,456,902.00
210104	Урамшуулал	34,787,366.00	84,560,436.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,479,013.00	88,170,771.12
210201	Тэтгэврийн даатгал	48,608,940.00	54,363,026.72
210202	Тэтгэмжийн даатгал	1,136,065.00	11,587,571.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,032,897.00	6,280,087.29
210204	Ажилгүйдлийн даатгал	5,626,320.00	1,973,978.21
210205	Эрүүл мэндийн даатгал	14,074,791.00	13,966,107.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	278,499,412.00	233,529,039.00
210301	Гэрэл, цахилгаан	15,714,736.00	13,467,055.00
210302	Түлш, халаалт	235,192,420.00	206,880,478.80
210303	Цэвэр, бохир ус	27,592,256.00	13,181,505.20
2104	Хангамж, бараа материалын зардал	12,709,071.90	9,872,771.37
210401	Бичиг хэрэг	1,723,728.25	1,298,940.00
210402	Тээвэр, шатахуун	140,000.00	360,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,102,838.00	1,100,000.00
210404	Ном, хэвлэл	119,100.00	234,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	894,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,373,405.65	5,985,831.37
2105	Нормативт зардал	1,037,946.50	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,037,946.50	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,414,596.40	10,507,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	8,500,000.00
210604	Урсгал засвар	46,414,596.40	2,007,200.00
2107	Томилолт, зочны зардал	695,300.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	695,300.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,588,038.00	798,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,588,038.00	798,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,210,428.42	135,909,842.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,350,152.00	367,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,483,391.55	11,097,660.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,376,884.87	124,444,682.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	178,408,767.00	86,655,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	176,812,400.00	85,625,000.00

Замын-Үүд ЕБ-ын 2 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,549,800.00	56,153,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,470,800.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	77,791,800.00	29,472,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,596,367.00	1,030,100.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,596,367.00	1,030,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	157,728,991.14	524,459,580.24
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	157,728,991.14	524,459,580.24

4.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,333,328,917.00	1,202,016,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,800,417.00	7,403,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,800,417.00	7,403,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,800,417.00	7,403,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,600,417.00	7,403,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,320,528,500.00	1,194,613,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,191,613,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,191,613,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,000,000.00
1330	Төсвийн захирагчдаас	1,320,528,500.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,320,528,500.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,310,411,538.00	1,174,546,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,310,411,538.00	1,174,546,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,131,847,771.00	1,083,812,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	706,165,089.00	719,093,057.00
210101	Үндсэн цалин	487,590,839.00	472,744,629.00
210102	Нэмэгдэл	176,577,484.00	172,610,692.00
210104	Урамшуулал	41,996,766.00	73,737,736.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,479,013.00	81,060,163.00
210201	Тэтгэврийн даатгал	48,608,940.00	54,039,976.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,136,065.00	6,755,110.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,032,897.00	5,404,047.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,626,320.00	1,351,111.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,074,791.00	13,509,919.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	278,499,412.00	238,527,500.00
210301	Гэрэл, цахилгаан	15,714,736.00	13,467,055.00
210302	Түлш, халаалт	235,192,420.00	211,878,939.80
210303	Цэвэр, бохир ус	27,592,256.00	13,181,505.20
2104	Хангамж, бараа материалын зардал	8,305,729.00	11,883,000.00
210401	Бичиг хэрэг	934,820.00	1,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,102,838.00	1,100,000.00
210404	Ном, хэвлэл	119,100.00	955,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,698,971.00	7,078,000.00
2105	Нормативт зардал	-	2,725,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,725,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,182,959.00	10,887,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	8,880,000.00
210604	Урсгал засвар	45,182,959.00	2,007,200.00
2107	Томилолт, зочны зардал	695,300.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	695,300.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,588,038.00	1,184,180.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,588,038.00	1,184,180.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,932,231.00	16,952,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,791,632.00	1,441,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,140,599.00	15,510,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	178,563,767.00	90,734,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	176,787,900.00	89,704,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,525,300.00	59,402,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,470,800.00	-

Замын-Үүд ЕБ-ын 2 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	77,791,800.00	29,472,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,000,000.00	830,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,775,867.00	1,030,100.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,775,867.00	1,030,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>22,917,379.00</u>	<u>27,470,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,917,379.00	27,470,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,917,379.00	27,470,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,917,379.00	27,470,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,917,379.00	27,470,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(22,917,379.00)</u>	<u>(27,470,000.00)</u>

4.4 АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,704,024,580.31	2,704,024,580.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,704,024,580.31	2,704,024,580.31
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	157,728,991.14	157,728,991.14
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,861,731,560.45	2,861,731,560.45
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,861,731,560.45	2,861,731,560.45
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,861,731,560.45	2,861,731,560.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	1,068,704,052.96	-	1,068,704,052.96
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	217,000,000.00	-	524,459,580.24	741,459,580.24
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	217,000,000.00	1,068,704,052.96	3,386,191,140.69	4,671,895,193.65

4.5 АУДИТАЛСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,191,613,800.00	1,190,583,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,191,613,800.00	1,190,583,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,102,739,200.00	1,101,709,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	716,599,100.00	719,093,057.00
210101	Үндсэн цалин	472,591,200.00	472,744,629.00
210102	Нэмэгдэл	166,924,200.00	172,610,692.00
210104	Урамшуулал	77,083,700.00	73,737,736.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,991,500.00	81,060,163.00
210201	Тэтгэврийн даатгал	56,880,900.00	54,039,976.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,110,300.00	6,755,110.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,688,100.00	5,404,047.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,480,200.00	1,351,111.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,832,000.00	13,509,919.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	236,729,000.00	238,527,500.00
210301	Гэрэл, цахилгаан	23,701,500.00	13,467,055.00
210302	Түлш, халаалт	197,000,000.00	211,878,939.80
210303	Цэвэр, бохир ус	16,027,500.00	13,181,505.20
2104	Хангамж, бараа материалын зардал	6,850,000.00	6,850,000.00
210401	Бичиг хэрэг	1,300,000.00	1,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	700,000.00	700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00	1,100,000.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,000,000.00
2105	Нормативт зардал	2,800,000.00	2,725,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800,000.00	2,725,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,507,200.00	26,507,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,500,000.00	8,500,000.00
210604	Урсгал засвар	18,007,200.00	18,007,200.00
2107	Томилот, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	1,184,180.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,184,180.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24262400.00	24262400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,441,500.00	1,441,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,820,900.00	22,820,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88874200.00	88874200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,874,200.00	88,874,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,402,200.00	59,402,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,472,000.00	29,472,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,191,613,800.00	1,191,613,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,191,613,800.00	1,191,613,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,191,613,800.00	1,191,613,800.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	84	84
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	57	57
620003	Үйлчлэх ажилтан	26	26